



НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/74

Улаанбаатар хот

Г Сахилга дэг журмыг сайжруулах тухай Г

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2013 оны “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ”-г шинэчлэн батлах тухай 446 дугаар тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 92 дугаар тушаал, Байгууллагын дүрмийн 2.6.3, 2.6.7, 2.6.9 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажлын хариуцлага, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх, эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудын үйл ажиллагаанд байнгын хяналт тавин ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулан илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулах, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг ханган ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан, Хүний нөөцийн алба, Чанарын алба, Сувилахуйн алба, Халдварын сэргийлэлт хяналтын алба, Тасгийн эрхлэгч нар, бүх алба, хариуцлагатнуудад,

2. Эмчлэх, эм барих, эх барих, сувилах, эм найруулах мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй ажилтнуудын мэргэжлийн түвшинг үнэлэн түвшин тогтоох шалгалтыг 2018 оны 4 дүгээр улиралд дахин авч үнэлэхийг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, Сувилахуйн албаны дарга, Инженер-Менежер нарт,

3. Ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглах, ажлын байранд худалдаа найм, сурталчилгаа хийхийг,

4. Эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажил үйлчилгээний өрөө байранд эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдаалах, стандартын бус эмчилгээ хийх, төлбөрт үйлчилгээг бэлэн мөнгөөр хийхийг тус тус хориглосугай.

5. Ажлын цаг ашиглалтыг хурууны хээ болон камерийн хяналтын системээр байнга бүртгэж түүнд тавих хяналтыг сайжруулахыг Программ хангамж сүлжээний инженер /А.Билгүүн/-д, бүртгэлийг үндэслэн цалин бодохыг Цалин хөлсний нягтлан бодогч /Б.Оюунтуяа/-д,

6. Ажилтнуудын гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, хяналт үнэлгээг тодорхой заалт шалгуураар хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахыг Дотоод хяналт шалгалт эрхэлсэн ажилтан, Хүний нөөцийн алба, Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэсгийн хороонд,

7. Ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах, ажилтны болон байгууллагын нэр төр гутаах үйлдлийг таслан зогсоож, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэн ажиллахыг албад, тасгийн эрхлэгч нарт,

8. Харуул хамгаалалт, өмч хамгаалалтанд байнгын хяналт тавин хяналтыг чангатгаж ажиллахыг Хангамж үйлчилгээний алба /О.Батдаваа/-д

9. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд мөрдөгдөх стандарт, хөдөлмөрийн дотоод журам, холбогдох бусад дүрэм журмыг чанд мөрдөж, ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргийг чанартай хийж гүйцэтгэхийг нийт эрүүл мэндийн ажилтнуудад,

10. Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолын дагуу хийх ажлын төлөвлөгөө болон дотуур багаар хийх хяналт үнэлгээний хуваарь гарган биелэлтийг сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг Байгууллагын бодлого, төлөвлөлт хариуцсан орлогч дарга /Д.Наранцацралт/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА  Г.БАЯСГАЛАН

1117136673
УХЕ0019 9077006